

Мөнгөний бодлогын хорооны хэвлэлийн бага хурлын протокол

2020.03.11

Мөнгөний бодлогын хорооны цахим хэвлэлийн бага хурал

Монголбанкны Тэргүүн Дэд Ерөнхийлөгч О.Эрдэмбилэг:

Коронавирусийн нөхцөл байдал дэлхийн эдийн засагт нөлөөллөө үзүүлээд эхэлсэн. Манай улсын хувьд гол төлөв гадаад хүчин зүйлсийн нөлөөгөөр эдийн засаг сүүлийн хэдэн улиралд нэлээд саарсан байгаа. Инфляци 2020 оны нэгдүгээр сарын байдлаар улсын хэмжээнд 5.6 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 6.0 хувьтай гарсан. Коронавирустэй холбоотойгоор эдийн засгийн идэвх саарах хандлага үргэлжлэхээр байна. Үүнтэй холбоотойгоор эрэлтийн шалтгаантай инфляци тогтвортой байх төлөвтэй хэдий ч, нийлүүлэлтийн шалтгаантай инфляцид хэлбэлзэл үүсэж болзошгүй байна. КОВИД вирусийн тархалт эдийн засагт нөлөөлж байгаа сувгуудын хувьд худалдааны суваг, түүхий эдийн суваг, тайлан балансын сувгаар орж ирж байна. Цаашид вирусийн тархах цар хүрээ, үргэлжлэх хугацаа, улс орнуудын вирусийн эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээнээс их зүйл шалтгаалахаар байна. Одоогийн байдлаар энэ нөхцөл байдал ид өрнөж байгаа учраас тодорхой бус байдал их байна.

Мөнгөний бодлогын хороо хуралдаж, эдийн засгийн тогтвортой байдал, банк санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилтын хүрээнд хэд хэдэн арга хэмжээг авлаа. Нэгдүгээрт, бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 10 хувьд хүргэх шийдвэр гаргалаа. Банкуудын төгрөгийн заавал байлгах нөөцийг 2 нэгж хувиар бууруулж, 8.5 хувьд тогтоохоор боллоо. Бодлогын хүүгийн коридорыг  $+2$  нэгж байсныг илүү нарийхан болгож,  $+1$  болгох шийдвэр гаргалаа.

Мөнгөний бодлогын хорооны гишүүн Ч.Хашчулуун:

Өнөөдөр мөнгөний бодлогын хорооноос гаргасан шийдвэрийн гол утга нь эдийн засгийн идэвхжлийг дэмжих чиглэлтэй байна. Сүүлийн саруудад эдийн засгийн байдал тодорхой хэмжээгээр муудаж, эдийн засгийн өсөлт буурах төлөвтэй байсан. Энэ арга хэмжээгээр эдийн засгийг идэвхжүүлэх, банкны системд байгаа төгрөгийн эх үүсвэрийн өртгийг бууруулж, зээлийн хамрагдалт, хүртээмжийг сайжруулах зорилготой юм. Энэ утгаараа Монголбанкны зүгээс эдийн засгийн хүндрэлтэй байдлаас гарахын тулд авч байгаа нэлээд шийдэмгий арга хэмжээ болж байна.

Мөнгөний бодлогын хорооны гишүүн Ц.Мөнхбаяр:

Зөвхөн бодлогын хүүг бууруулах бус цогц арга хэмжээ юм. Мөнгөний бодлогын нөлөөллийг сайжруулах, богино болон дунд хугацаанд үйлчлэх үйлчлэлийг илүү хүчтэй болгох, гэнэтийн шокийн эсрэг арга хэмжээ юм. Бодлогын хүүгийн коридорыг нарийсгаж байгаа нь банкуудын төлбөрийн чадварыг сайжруулах, эх үүсвэрийн өртгийг бууруулах зорилготой юм. Энэ нь мөнгөний бодлогын бусад шийдвэртэйгээ нийлээд, бодлогын үр нөлөөг сайжруулахад чухал ач холбогдолтой.

Мөнгөний бодлогын хорооны гишүүн Ц.Батсүх:

Гадаад, дотоод эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан эдийн засгийн агшилттай үед эрэлтийн талын инфляцийн дарамт багасч байгаа. Энэ үед эдийн засгийн идэвхжлийг сайжруулах зорилгоор бодлогын хүүг 1 нэгж хувиар буурууллаа. Нөгөө талдаа банкуудын тогтвортой байдлыг хангах зорилгоор хөрвөх чадварын эрсдэлээс сэргийлж, заавал байлгах нөөцийн хувь хэмжээг буурууллаа. Түүнчлэн пассивын долларжилтыг бууруулахад анхаарч, төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг бууруулан шийдвэр гаргалаа.